

**Хууль сахиулахын их сургуулийн багш,  
судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний  
өгүүллийн чанарын судалгаа**

**СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

**(2016)**

**“ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН БАГШ, СУДЛААЧДЫН НИЙТЛҮҮЛСЭН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛИЙН ЧАНАРЫН СУДАЛГАА”-НЫ ТАЙЛАН  
(2012-2016)**

**УДИРТГАЛ**

Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудыг эрэмблэдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэд хэдэн байгууллага байдаг бөгөөд тэдгээрийн судалгааны арга, шалгуур үзүүлэлт хоорондоо ялгаатай ч эрдэм шинжилгээ, судалгааны ажилд онцгой ач холбогдол өгдөг байдлаараа нийтлэг гэж хэлж болно.

Энэхүү хөгжлийн хандлага нь Монгол Улсын боловсролын салбарт нэвтэрч, Монгол Улсын Засгийн газраас их, дээд сургуулиудыг судалгааны их сургууль болгон өөрчлөхөд чиглэгдсэн олон талт арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлж байна<sup>502</sup>. Энэ ажлын хүрээнд 2011 онд хууль сахиулах салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургууль байгуулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын ... дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан нь хууль сахиулах ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, нөгөө талаараа энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, эрдэмтэн, судлаачдын бүтээлийн чанарыг сайжруулах үндсийг тавьсан үйл явдал болсон билээ.

**Судалгааны сэдвийн үндэслэл, тулгамдсан байдал:** Хууль сахиулах ажиллагааны талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, энэ чиглэлийн тулгамдсан асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт өгөх явдал манай сургуулийн эрдэмтэн, судлаачдын нэн чухал зорилт болоод байна.

Хууль сахиулахын их сургуулийн хөгжлийн чиг хандлага, нэр хүнд түүний дотор эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чансаа олон улсын болон дотоодын их, дээд сургууль, судалгааны байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь эдгээрийг гардан гүйцэтгэгч эрдэмтэн, судлаачдын бүтээлийн чанар, тэдгээрийг хөхүүлэн дэмжих сургуулийн бодлогоос шууд шалтгаалах нь тодорхой юм.

Энэ учир шалтгааны үүднээс эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тэр дундаа судалгааны ажлын явцын ба эцсийн үр дүнг тухайн салбарын хэрэглэгчдэд дамжуулж, оюуны бүтээлийг эргэлтэд оруулдаг эрдэм шинжилгээний нийтлэлийн нэг чухал хэлбэр болох эрдэм шинжилгээний өгүүлэл, түүний чанарын талаар судаллаа. Энэ асуудлыг онцлон судлах хэд хэдэн үндэслэл байсан. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний өгүүллийн гүйцэтгэх үүргээс түүний онол, арга зүйн түвшин, чанарыг дээшлүүлэх зорилт урган гарч байна. Аливаа хөгжил, дэвшлийн хөрс суурь нь үзэгдэл, юмсын тухайн үеийн төлөв байдал байдгийг үндэс болговоос Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын өнөөгийн түвшинг тодорхойлох нь түүнийг боловсронгуй болгон хөгжүүлэх чухал урьдчилсан нөхцөл юм.
2. Судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх зорилгоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн ДХИС, ХСИС болгон өргөтгөн зохион байгуулаад 5 жил, ХСИС-ийг түшиглэн Докторын ажил хамгаалуулах зөвлөл байгуулагдаад 2 жил, Хууль сахиулах их сургуулийн профессорын судалгааны багийг мэдлэгийн тодорхой

<sup>502</sup> 1998 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”, түүнийг удирдлага болгон “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого 2012-2016” зэрэг бодлогын баримт бичгүүд хамаарна.

салбараар төрөлжүүлэн байгуулаад 1 жил гаран болж байгаа хэдий ч олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн шинжлэх ухааны салбарт ишлэл авах эрх бүхий импакт, фактор бүхий сэтгүүлд тус сургуулийг төлөөлсөн эрдэм шинжилгээний өгүүлэл өнөөг хүртэл нийтлэгдээгүй,

3. Олон улсын болон дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний чанартай өгүүлэл нийтлүүлэх талаар сургуулийн хөгжлийн хөтөлбөр, ажил дүгнэх үзүүлэлтүүдэд тусгасан боловч эрдэм шийнжилгээний өгүүлэл хэрхэн бичих, олон улсын түвшинд эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах наад захын жишиг шаардлага, судалгааны арга зүй болон хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авдаг сэтгүүлийн жагсаалт, түүнд бүтээлээ илгээх аргачилсан зөвлөмж тус сургуулийн бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй,
4. Багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чиг үүрэг бүхий албан хаагчид, эрдмийн зэрэг, цолтой судлаачдын тоо жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч дотоодын болон тус их сургуулиас эрхлэн гаргадаг мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх судлаачдын тоо төдийлөн нэмэгдээгүй,
5. Эрдэм шинжилгээний өгүүллийн тоо, түүний чанар нь тухайн сургуулийн чансааг илэрхийлэх гол шалгуур болдог бөгөөд энэ талаар бусад их, дээд сургуулиуд дангаараа болон хамтарсан байдлаар хэд хэдэн судалгааны ажил хийж, түүний чанарыг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлсэн бол манай сургуулийн хувьд энэ асуудлаар тухайлсан судалгаа хийгээгүй явдал нь онол, практикийн аль ч түвшинд эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг тодорхойлох шаардлагатай байгаа бодит байдлыг харгалзан үзсэн болно.

**Судлагдсан байдал:** Сүүлийн жилүүдэд дотоодын их, дээд сургууль, судалгааны байгууллагууд эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын асуудалд анхаарал хандуулж, хэд хэдэн судалгааны ажил хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Тухайлбал, 2016 онд Дээд боловсрол судлалын Монголын нийгэмлэг төрийн бус байгууллагаас санаачлан Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын их, дээд сургуулиудын консорциум, Монгол Улсын Боловсролын их сургуультай хамтран “Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулахад тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт симпозиум зохион байгуулжээ. Харин манай сургууль энэ асуудлаар тухайлсан судалгаа хийгээгүй.

**Судалгааны зорилго:** Энэхүү судалгааны зорилго нь Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын судалгаа хийх, цаашид өгүүллийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн санал, зөвлөмж боловсруулахад оршино. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний өгүүллийн ойлголт, хэлбэр, түүнд тавигдах шаардлага, ач холбогдлыг тодорхойлох;
2. Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын сүүлийн 5 жилийн хугацаанд нийтлүүлсэн 50 эрдэм шинжилгээний өгүүллийг санамсаргүй түүврийн аргаар сонгож дүн шижилгээ хийх;
3. Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулах, шинжилгээний өгүүлэл бичих, олон улсын болон дотоодын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ илгээх, хэвлүүлэх алхамт загварын талаар аргачилсан зөвлөмж боловсруулах-зэрэг болно.

**Судалгааны арга, арга зүй, хэрэглэгдэхүүн:** Судалгааны зорилготой уялдуулж Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургууль, Хилийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургуулийн багш, судлаачдын сүүлийн 5 жилийн хугацаанд их сургуулиас эрхлэн гаргадаг “Хууль сахиулахуй”, “Гэмт явдалтай тэмцэх асуудал”, “Цагдаа судлал”, “Шүүхийн

шийдвэр гүйцэтгэл судлал”, “Гамшгийн эрсдэл судлал”, “Хил судлал”, “Хууль сахилахуйн удирдлага” зэрэг онол, арга зүй-мэдээллийн сэтгүүлд нийтлүүлсэн 50 өгүүллийг санамсаргүй түүврээр сонгон (хавсралт №1-ийг үзнэ үү) эрдэм шинжилгээний өгүүллийн олон улсад мөрдөж байгаа стандарт, бүтцийн дагуу 10 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 20 дэд үзүүлэлтээр Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноогоор үнэлж, өгүүллийн чанарын түвшинг сонгож авсан шинжлэх ухааны салбар тус бүрээр болон нэгдсэн дүнгээр тодорхойлов.

Судалгааг экспертийн үнэлгээ, контент анализын аргаар явуулж, судалгааны баримт, мэдээллийг SPSS програм, Excel Data analysis ашиглан математик, статистикийн аргаар боловсруулан, тоон болон чанарын анализ хийв. Үзүүлэлт бүрийн жигнэсэн дундаж, дээд, доод утга, моод, медиан, корреляцийн коэффициент зэрэг статистик үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг статистик шинжүүрийн тусламжтайгаар тооцон тодорхойлж, зохих сорил шинжүүрээр шалгаж магадлав.

**Судалгааны ач холбогдол, шинэлэг тал:** Эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэр, шаардлагын талаар манай улсын хэд хэдэн эрдэмтэн, судлаач өөрсдийн бүтээлд тэмдэглэсэн боловч хууль зүйн салбар тэр дундаа Хууль сахиулах их сургуулийн багш, судлаачдын бүтээлд анхаарал хандуулсан судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй байна. Иймд Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын дотоодын зарим сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг тодорхойлох нь Их сургуулийн хөгжлийн стратеги хөтөлбөр (2016-2025 он)-т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх онол, практикийн ач холбогдлоор энэхүү судалгааны ажлын шинэлэг тал илэрнэ.

Эрдэм шинжилгээний нийтлэлийн хэлбэрүүдээс бид “Судалгааны өгүүлэл”-ийн чанарын асуудлыг авч үзсэн бөгөөд бидний судалгааны онцлог нь эрдэм шинжилгээний өгүүллийг “судалгааны объект” болгон тусгайлан судалсанд оршино.

**Судалгааны ажлын хязгаарлалт:** Энэхүү судалгааны ажлын мэдээллийн эх сурвалж нь зөвхөн Хууль сахиулах их сургуулийн багш, судлаачдын сүүлийн 5 жилийн бүтээлд тулгуурлагдсан бөгөөд дараагийн судлаачид судалгааны объектыг хууль сахиулах салбарын хүрээнд бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүллийг бүхэлд нь, эсхүл урт цаг хугацааг хамарсан байдлаар өргөжүүлэн судлах боломжтой.

**Судалгааны баг, хугацаа:** Судалгааны багийн ахлагчаар доктор (Ph.D), цагдаагийн хурандаа О.Зоригт, нарийн бичгийн даргаар доктор (Ph.D), цагдаагийн хошууч С.Гантулга, гишүүдээр доктор (Ph.D), профессор, хурандаа Н.Гантулга, доктор (Sc.D), профессор Ж.Долгорсүрэн, доктор (Ph.D), профессор А.Лхагва, А.Муратхан, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Б.Энхболд нар ажиллаж, “Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын судалгаа”-г хийв.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛИЙН ОЙЛГОЛТ, ХЭЛБЭР, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ

### **1.1.Эрдэм шинжилгээний өгүүлэл нь их сургуулийн эрэмбэ тогтоох гол шалгуур болох нь**

Эрдэм шинжилгээний зохиолын богино хэмжээний хамгийн нийтлэг бөгөөд шинжлэх ухаанд үйлчлэх үүргээрээ түгээмэл хэлбэр нь эрдэм шинжилгээний өгүүлэл юм. Өгүүлэл нь эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, дүгнэлт өгсөн, шинжлэх ухааны тодорхой мэдээллийг агуулсан бие даасан бичил зохиол юм. Судлаач бүхэн судалгааны ажлынхаа явцад түүний зарим үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэх үүрэгтэй. Нөгөө талаар, олон улсын хэмжээнд их, дээд сургуулийн чансааг тодорхойлоход тухайн их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд анхаарч буй байдал, мөн тухайн сургуулийн эрдэмтдийн туурвисан бүтээл чухал нөлөө үзүүлдэг. Энэ шалгуурт үндэслэн судалгаанд суурилсан их сургууль буюу Research university гэх ойлголт гарч ирсэн.<sup>503</sup>

Одоогоор их, дээд сургуулиудыг эрэмбэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 3 шинжээчдийн баг (*Academic Ranking of World Universities –ARWU, Times Higher Education World University Ranking, QS World University Rankings*) байна. Эдгээр байгууллагын дэлхийн их, дээд сургуулиудын чансааг тодорхойлохдоо баримталдаг шалгуур үзүүлэлтүүдийг авч үзвэл *Academic Ranking of World Universities (ARWU)* гэсэн нэрээр олонд танигдсан Дэлхийн их, дээд сургуулиудын эрэмбэ тогтоох судалгааны баг нь БНХАУ-ын Shanghai Jiao Tong их сургуулийн дээд боловсролын хүрээлэнд хамаардаг. ARWU нь академик сургалт болон судалгааны ажлын гүйцэтгэлд үндсэн 6 үзүүлэлтийг баримталж их, дээд сургуулиудыг эрэмбэлэдэг байна. Дээрх шалгуур үзүүлэлтүүдээс 3 буюу 60 хувь нь багш, судлаачдын эрдэм шинжилгээний өгүүлэл, ишлэл авсан бүтээл, судалгааны ажилд тулгуурладаг байна. (Хүснэгт-1)

Харин *Times Higher Education World University Ranking* буюу Британийн Times Higher Education сэтгүүлээс гаргадаг энэхүү их, дээд сургуулийн эрэмбэ нь Thomson Reuters-ийн ишлэл болсон бүтээлийн талаарх мэдээллийн баазад түшиглэдэг байна. Ерөнхий болон шинжлэх ухааны салбар тус бүрээр их, дээд сургуулийг эрэмбэлэх бөгөөд сургалт, судалгаа, мэдлэгийн хөрвөлт, олон улсын түвшинд үнэлэгдэх байдал зэргийг багтаадаг судалгаа юм. Тус сэтгүүл нь их, дээд сургуулийн эрэмбэ тогтоохдоо ерөнхий 4 үзүүлэлт, нарийвчилсан 16 үзүүлэлтийг удирдлага болгодог ба 42.25 хувьд нь багш нарын эрдэм шинжилгээний өгүүлэл, түүнээс ишлэл авсан байдлыг харгалзадаг байна.

*QS (Quacquarelli Symonds) World University Rankings* нь дэлхийн их, дээд сургуулиудын эрэмбийг ерөнхий болон шинжлэх ухааны салбар тус бүрээр гаргахын зэрэгцээ, бүс нутгаар нь эрэмбэлдэг. QS нь их, дээд сургуулийн эрэмбийг тогтоохдоо үндсэн 5 шалгуур үзүүлэлтийг баримталдаг. Шалгуур үзүүлэлтийн 20 хувь нь багш нарын эрдэм шинжилгээний өгүүлэл, түүнээс ишлэл авсан байдалд үнэлэлт өгдөг байна.

Дээрх судалгааны багуудын шалгуур үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл, их, дээд сургуулийг үнэлэх чухал үзүүлэлтүүдийн нэг бол тухайн сургуулийн эрдэмтдийн бүтээл, судалгааны ажил байна. Энэ ч утгаараа дээрх эх сурвалжуудын шалгуур үзүүлэлтэд ишлэл болж буй бүтээлийн эзлэх хувь өндөр байдаг.

### **1.2.Эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл, арга зүй, тавигдах шаардлага**

Эрдэм шинжилгээний өгүүллийг амжилттай бичих эхний алхам бол ямар судалгааны эх сурвалжид тулгуурлан өгүүлээ бичихээс шалтгаалдаг. Иймээс судалгааны эх сурвалжаас шалтгаалан эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл тодорхойлогддог байна. Орчин үед

<sup>503</sup> “Монголын боловсрол-инноваци” сэтгүүл. 2015. №1. 18-20 дахь тал

эрдэмтэн, судлаачдын бичиж байгаа эрдэм шинжилгээний өгүүлэлд дүн шинжилгээ хийж үзвэл дараах нийтлэг 7 төрөлд хуваагдаж байна.

**Тохиолдолд шинжлэх хэлбэрийн өгүүлэл:** (Case Study). Тодорхой нэг болон жижиг бүлэг асуудалтай холбогдсон нөхцөл байдал эсвэл түүнийг онцлог, мөн чанарыг нээн илрүүлэх зорилгоор явуулсан судалгааны үр дүнд үндэслэн бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл. Энэ төрлийн өгүүлэл нь ихэнх тохиолдолд амьдралд бодитойгоор оршин буй юмс үзэгдэлд дүн шинжилгээ хийдэг. Тухайлбал, хүнийг санаатай алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа гэмт буруугийн шууд болон шууд бус санааг хэрхэн харгалзаж байгааг тогтоох зорилгоор шүүхээр шийдвэрлэгдсэн ижил төстэй 50 хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх.

**Санал асуулгын үр дүнг илтгэх өгүүлэл:** (Survey study). Тодорхой үзэгдэл, үйл явдлын талаар олон хүнийг хамарсан судалгааг бичгэн хэлбэрийн санал асуулгын хуудас, эсхүл асуултад хариулаад буцааж илгээх цахим хэлбэрийн санал асуулга болон оролцогчтой шууд ярилцах хэлбэрээр цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар бичсэн өгүүлэл. Энэхүү судалгааны үр дүнгээр тухайн сонирхож буй үзэгдэл, үйл явдлын талаар олон нийтийн хандлага, өмнөх судалгааны ажилтай ижил болон ялгаатай дүгнэлтүүдийг хийж болдог. Тухайлбал, “Монголчуудын цагдаад итгэх хандлага”-ыг тогтоох зорилгоор Улаанбаатар хотын 1000 хүнээс дунд тусгайлан боловсруулсан санал асуулгын хуудсаар 2 сарын хугацаанд судалгаа авч, дүгнэлт хийсэн байна. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо судалгааны арга зүйд тулгуурлан сонгох шаардлагатайг анхаарах шаардлагатай.

**Ажиглалтын судалгааны үр дүнг илтгэх өгүүлэл:** (Observational research). Ажиглалт нь аливаа юмс үзэгдлийг оршин буй бодит нөхцөл байдалд нь болон лабораторийн нөхцөлд ажиглах гэсэн 2 хэлбэртэй байх бөгөөд аль аль нь судалж буй юмс үзэгдэлд ямар нэгэн өөрчлөлт байгаа эсэх талаар хариулт өгдөг. Ажиглалтын үр дүнг илтгэх өгүүлэл нь зарим тохиолдолд санал асуулгын аргаар бичигдсэн өгүүллийн үр дүнг өөрчилдөг байна. Тухайлбал, Италийн нэрт криминологич, позитивист криминологийн урсгалыг үндэслэгч Ч.Ломброзо “Гэмт хэрэгтэн бие хүний онол”-ыг боловсруулахдаа Италийн шоронгийн хоригдлуудын дунд 17 жилийн турш ажиглалтын аргаар судалгаа явуулсан байна.


**Харилцаа хамаарлын үр дүнг илтгэх өгүүлэл:** (Correlational research). Харилцаа хамаарлыг тогтооход чиглэгдсэн өгүүлэл нь нийгэмд бодитоор оршин тогтнож буй хоёр үзэгдлийн хооронд харилцан хамаарал байгаа эсэх, түүний хамаарлын хүч ямар түвшинд байгааг тодорхойлохыг оролддог. Тухайлбал, бид “Ажилгүйдэл ба гэмт хэрэг”, “Согтуурал ба гэмт хэрэг”, “Авлига ба гэмт хэрэг” гэсэн хоорондоо уялдаа бүхий хоёр үзэгдлүүдийг тогтмол гэмт хэргийн шалтгаан гэж тайлбарлаж ирсэн боловч тэдгээрийн хамаарлыг тогтоосон нарийвчилсан судалгаа хараахан хийгдээгүй байна. Харин 2007 онд АНУ-ын Вашингтоны их сургуулийн эрдэмтэд “Авлига ба гэмт хэргийн төрөл” сэдэвт харьцуулсан судалгааг 50 улсын түвшинд статистикийн коррелляцын аргаар хийсэн байна. Судалгааны үр дүн нь Авлигын түвшин өндөр улс оронд ахуйн хүрээнд үйлдэгддэг хүч хэрэглэсэн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн түвшин өндөр байгааг харуулсан байна. Харин авлигын түвшин буурах тусам дээрх төрлийн гэмт хэргийн гаралт буурч, эсрэгээрээ албан тушаалын гэмт хэргийн тоо ихсэж байгааг тогтоосон байна.

**Тайлбарласан өгүүлэл:** (Descriptive study). Тодорхой асуудлыг тайлбарлах, эсхүл ямар нэгэн ойлголтын талаар мэдээлэл олж авах, бусдад түгээхэд чиглэгдсэн ерөнхий болон өвөрмөц нөхцөл байдлыг тодорхойлон тайлбарласан өгүүлэл юм. Ийм хэлбэрийн өгүүлэл нь ихэвчлэн ямар нэгэн бүтэц, загварт баригддаггүй бөгөөд олон улсын эрдэм шинжилгээний хурлын үндсэн илтгэл, улс хоорондын харилцан ажиллагааны үед өөрийн талын байр суурийг илэрхийлэх болон бусад бодлогын шинжтэй хурал, зөвлөгөөнд түгээмэл хэрэглэгддэг. Түүнээс гадна зарим нэр томъёо, онолын маргаантай ойлголтыг тайлбарлан нэг мөр хэрэглэх зорилгоор энэ хэлбэрийн өгүүллийг бичдэг байна. Өгүүллийн үр дүн нь

ихэвчлэн тулгамдсан асуудал байгаа эсэхийг илрүүлэх, тухайн салбар, нөхцөл байдлын талаар мэдээлэл, мэдлэгтэй болгох, эсхүл цаашид хийх судалгааны ажлын чиг хандлагыг тодорхойлох болон тодорхой таамаглалуудыг бий болгодог байна. Тухайлбал, 2013 онд Хууль сахиулахын их сургуулиас зохион байгуулсан “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор С.Жанцан агсаны хэлэлцүүлсэн “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын мөн чанар, бодит байдал, чиг хандлага” илтгэлийг дурдаж болно.

**Туршилтын үр дүнг илтгэх өгүүлэл:** (Experimental research). Туршилтын судалгаанд тулгуурласан өгүүлэл нь хэд хэдэн хамаарах хувьсагчууд нь (dependent variable) сонгож авсан үл хамаарах хувьсагчид (independent variable) хэрхэн нөлөөлж байгааг математик, статистикийн аргачлалаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан тайлбарлах хэлбэрээр бичигддэг. Тухайлбал, доктор (Ph.D) Б.Энхболд “Уугуул Монголчууд ба БНСУ-д оршин суугаа Монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулсан судалгаа: инструментал болон экспрессив загварчлалаар шалгах нь” сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээлдээ энэ хэлбэрийг ашигласан байна. Загвар 1-т үзүүлснээр судлаач үл хамаарах хувьсагчаар “Цагдаад итгэх олон нийтийн хандлага” гэсэн 1 хувьсагч, түүнд нөлөөлж болох хамаарах хувьсагчуудаар дараах 10 хувьсагчийг сонгон шалгалт хийж монголчуудын цагдаад итгэх хандлагыг тодорхойлсон байна. Үүнд: 1) гэмт хэргийн чиг хандлага, 2) гэмт хэрэгт хохирох явдал, 3) гэмт хэргээс айх хандлага, 4) нийгмийн эмх замбраагүй байдал, 5) нийгмийн гишүүдийн хоорондын харилцаа, 6) албан бус нийгмийн хяналт, 7) оршин суугчийн статус, 8) Солонгос хэлний мэдлэгийн түвшин, 9) Солонгосын соёлд ууссан байдал, 10) найз нөхдийн холбоо зэрэг болно.

*Загвар-1. Монголчуудын цагдаад итгэх хандлагыг шалгах загвар*



**Соёлын ялгаатай үндэстэн, улс хоорондын түвшинд явуулсан судалгааны үр дүнг илтгэх өгүүлэл:** (Cross-Cultural reaserch). Нэг улсын хүн амын дунд суурьшсан соёлын хувьд ялгаатай жижиг үндэстэн, угсаатны зүгээс ямар нэгэн нийгмийн үзэгдэлд хандах хандлага болон судлан буй үзэгдлийн хувьд өөр өөр улс хоорондын соёл, онцлогт хадгалагдах ялгаатай болон нийтлэг шинжийг илрүүлэхэд чиглэгдсэн өгүүлэл хамаарна. Энэ хэлбэрийн илтгэлийг ихэвчлэн санал асуулга болон ажиглалтын аргаар явуулсан судалгаанд тулгуурлан бичдэг. Тухайлбал, өөр хоорондоо ялгаатай улсуудын эрх зүйн зохицуулалт,

гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийг шашны онцлогоор нь харьцуулан судлах зэрэг өгүүллүүд бичигддэг байна.

### 1.3. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах бүтцийн шаардлага

Судлаачид өөрийн судалгааны үр дүн, ололт, нээлтийг бусадтай хуваалцахын тулд өгүүлэл хэлбэрээр олон нийтэд түгээх шаардлагатай болдог. Тиймээс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлд судлаачдын өгүүлэл, судалгааны ажлыг хүлээн авахдаа хэлбэр, бүтцийн хэд хэдэн шаардлага тавьдаг. Өөрөөр хэлбэл, судлаачид өөрсдийн бичсэн өгүүллийг тухайн сэтгүүлийн шалгуурт нийцүүлэх зайлшгүй шаардлагатай болдог. Тэдгээр нийтлэг шалгуурууд нь зөвхөн сэтгүүлүүдийн хүрээнд яригдах бус судлаачид зайлшгүй эзэмшсэн байх ёстой мэдлэг, чадвар, ёс суртахууны тухай цогц ойлголт юм. Учир нь мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүлэл нь тусгай загвар, баримталдаг журамтай, түүгээр дамжуулж эрдэм шинжилгээ, судалгааны орчинд мөрдөгдөх дэг жаягийг бий болгодог. Судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэхийн зэрэгцээ өөрийн орчинд эрдэм шинжилгээний ажлын соёлыг бий болгож, түүнийг бусад судлаачид болон оюутнуудад дамжуулж байдаг.

Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцэд дараах элементүүдийг ерөнхий болон дэд шалгуур үзүүлэлт болгон авч үздэг байна. Үүнд: Өгүүллийн нэр, хураангуй, түлхүүр үг, удиртгал, судлагдсан байдал, үндсэн хэсэг, хэлэлцүүлэг, дүгнэлт, санал, ашигласан материалын жагсаалт, зохиогчийн тухай мэдээлэл зэрэг болон өгүүллийн чанарт зайлшгүй харгалзах зүйл болох ишлэл авсан байдал, бичиглэл зэргийг үнэлгээний ерөнхий шалгуур-үзүүлэлтээр авч, эдгээр шалгуурын илрэх шинжийг дэд үзүүлэлт болгон авсан. Эдгээр дэд үзүүлэлт нь үнэлгээний хэмжилт хийх шинжүүд юм. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах 10 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 20 дэд үзүүлэлтийг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт №1

Судалгааны өгүүллийн чанарт тавигдах ерөнхий ба дэд шалгуур үзүүлэлт	
Үнэлгээний ерөнхий үзүүлэлт (Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэц)	Үнэлгээний дэд үзүүлэлтүүд
1. Өгүүллийн нэр Title (Өгүүллийн нэр нь сэдэв, агуулга, үр дүнгийн мөн чанарыг, илэрхийлэхийн зэрэгцээ, уншигчийн хэрэгцээ, сонирхол татахуйц байх)	1.1.Өгүүллийн нэр нь өгүүллийн агуулгыг оновчтой илэрхийлэхүйц судалгааны мөн чанарыг тусгасан цөөн үгээр илэрхийлсэн байх; (10 хүртэл үг) 1.2.Өгүүлбэр зүй, Монгол хэлний зөв бичих дүрмийн алдаагүй байх.
2. Хураангуй Abstract (Юу хийсэн?) (Хураангуй нь өгүүллийн нэрийн өргөтгөсөн хувилбар буюу тухайн өгүүллийн талаар зохиогчоос хийсэн тодорхойлолт юм.)	2.1.Судалгаанд ямар сэдвийг, ямар үндэслэлээр сонгон судалснаа товч тодорхойлох; ( <b>Ямар асуудлыг, яагаад сонгон судалсан?</b> ) 2.2.Судалгаагаанд ямар асуудлыг, яаж шийдвэрлэсэн; ( <b>Юуг, яаж хийсэн?</b> ) 2.3.Судалгааны үр дүн нь бусад судлаачдын төстэй судалгааны үр дүнгээс ямар ялгаатай. ( <b>Юуг шинээр батлан тогтоосон буюу шинэчлэн сайжруулсан?</b> ) 2.4.Хураангуйгаас өгүүллийн талаар ерөнхий ойлголт авах боломжтой эсэх, зохих хэмжээндээ бичигдсэн байх (250 үгэнд багтсан байх).



3. Түлхүүр үгс Keywords	<i>3.1.Түлхүүр үгийг сонгож хэрэглэсэн байдал (Өгүүллийн үндсэн утга санааг төлөөлөхүйц 5 хүртэл үгийг нэрлэхийн тийн ялгалын ганц тоонд бичих, гарчигны үг оруулж болно)</i>
4. Удиртгал хэсэг (Оршил) Introduction	4.1.Судалгааны объект, зорилго, зорилтоо тодорхойлж, таамаглал дэвшүүлсэн байдал; 4.2.Тухайн судалгааатай холбоотой өмнөх эх сурвалжийн судалгаа, ишлэл авсан байдал; 4.3.Судалгааны ажлын шийдвэрлэвэл зохих тулгамдсан чухал асуудал болохыг илэрхийлсэн байдал.
5. Судлагдсан байдал Literature review	5.1.Судалгааны объектыг бусад судлаачид судалсан байдал, тэдний арга, аргачлал
6. Үндсэн хэсэг	6.1.Онолын үндэслэл 6.2.Таамаглал дэвшүүлсэн байдал (Hypothesis) 6.3.Дэвшүүлсэн таамаглалыг шалгах судалгааны арга, аргачлал (Судалгаанд хэрэглэсэн арга, аргачлал, хэрэглэгдэхүүн, туршилт, хугацаа, түүвэр, хамарсан хүрээ, үр дүнгийн боловсруулалт) Уг судалгааг тухайн арга, аргачлалаар өөр судлаач давтан хийхэд боломжтой, ойлгомжтой байх; 6.4.Судалгааны үр дүнг илэрхийлсэн байдал ( <b>Оршилд дэвшүүлсэн таамаглал хэрхэн батлагдсан, үр дүнгийн баталгаа, бодит байдал</b> ).
7. Хэлэлцүүлэг Discussion	7.1.Судалгааны ач холбогдол, түүний үр дүнг практикт хэрхэн хэрэглэх; 7.2.Бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, зөвлөмж, санал дэвшүүлсэн байдал; 7.3.Судалгааны цаашдын чиглэл, алхам юу байх.
8. Дүгнэлт, санал Conclusion, recommendation (Ямар үр дүнд хүрэв?)	<i>8.1.Дэвшүүлсэн зорилго, таамаглалтай холбож, судалгааны үр дүнгээс дүгнэлт гаргасан байдал; (Дүгнэлт нь онол, практикийн ач холбогдолтой цөөн 3-5 заалтыг тезис хэлбэрээр бичсэн, дүгнэлт нь хураангуйтай давхцахгүй байх)</i> 8.2.Дэвшүүлсэн санал бодитой, судалгаагаар нотлогдсон, практикт хэрэгжих, үр дүнд хүрэх боломжтой эсэх.
9. Ашигласан материал Reference	7.1.Ашигласан материалыг Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг баримтлан бичсэн байдал.
10. Бичлэгийн стандарт, зааврыг баримталсан байдал	10.1.Олон Улсын болон Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг баримталсан байдал; ( <b>Энэ нь эрдэм шинжилгээний өгүүлэл бичих олон улсын нийтлэг жишигт хэрхэн нийцэж байгаа</b> ) <i>9.2.Монгол хэлний зөв бичих дүрэм, техникийн алдаагүй байх.</i>
11.Ишлэл авсан байдал	11.1.Ишлэлийг олон улсад мөрдөж байгаа журамд нийцүүлэн хийсэн байдал (APA, MLA болон бусад)

#### 1.4.Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загвар<sup>504</sup>

<sup>504</sup> Т.Уранчимэг. “Судалгааны өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загвар” судалгааны өгүүлэл. “Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулахад тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт сипозиумын илтгэлийн эмхтгэл. Дээд боловсрол судлалын Монголын Нийгэмлэг. УБ., 2016. 25-28 дахь тал

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих тухай ойлголт одоогоос хэдхэн жилийн өмнө өнөөдрийнх шиг ийм нээлттэй бас олон хүн анхааран үздэг сэдэв байсангүй. Хориодхон жилийн өмнө эрдэм шинжилгээний өгүүллийг бичдэг болоод бичих талаарх аргачлалын тухайд мэддэг хүмүүс зөвхөн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид, цөөн тооны профессорууд байв. Дэлхийн хөгжилд томоохон өөрчлөлт авчирсан дэвшилтэт тоон технологи, интернэт нь эрдэм судлалын ажилд ч өргөн боломжийг дэлхийн улс оронд нээж өгсний бас нэгэн илрэл бол эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ улам бүр өсөн нэмэгдэж түүнд оролцох хүмүүсийн тоо өсч, бүтээл үр дүн нь хүмүүсийн өдөр тутмын олон зүйлд амжилттай хэрэгжиж эхлээд байгаа явдал юм.

Эрдэм судлалын ажил өргөжсөний нэг тод илрэл бол эрдэм шинжилгээний ажлыг зөвхөн гүн ухааны, байгалийн, анагаахын, техникийн зэрэг уламжлалт шинжлэх ухаанд өргөн ашиглаад зогсохгүй нийгмийн, боловсролын болон бусад олон салбаруудад өргөн фронтоор хийдэг болсон явдал юм. Энэ утгаараа эрдэм судлалын ажил, судалгааны ажлыг зөвхөн эрдэмтэд хийдэг байсан цаг үе нэгэнт ард хоцорч одоо судалгааны ажил хийх хүсэлтэй хүмүүс хүссэн чиглэлээрээ судалгаа хийх боломжтой болоод байна. “Эрдэмтэн” гэсэн үг бидний хэрэглээнээс улам бүр холдож харин “судлаач” гэдэг үг олонтаа ашиглагдах болсон нь үүнийг батлах өөр нэгэн үзэгдэл юм.

Эрдэм судлалын ажлын тайлагнах хэлбэрүүдийн нэг болсон эрдэм шинжилгээний өгүүллийг бичих процессийг системийн онолд тулгуурлан алхамт загварын аргачлалаар тайлбарлая.

### **1. Өгүүлэл бичих арга зүй**

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүйн тухай хэлэлцэхийн өмнө судалгаа, шинжилгээний ажлыг хийх шаардлага болоод хэрхэн судалгааны ажил хийх талаар товчхон авч үзье. Ч.Авдай, Д.Энхтуяа (2007) “Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй” номондоо тодорхойлсныг иш татвал: Аливаа судалгаа шинжилгээний ажил нь тодорхой зорилго, төлөвлөгөө, үе шаттай явагдана. Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ дараах дэс дарааллыг баримтлана. Үүнд:

- Судалгаа шинжилгээний ажлын сэдвийг сонгож зорилгоо тогтоох;
- Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судалж зохих дүгнэлт өгсөн байх;
- Энэхүү дүгнэлт дээрээ үндэслээд уг объектын хувьд чухам юуг ялган авч судлах гэж байгаа, өөрөөр хэлбэл зорилтоо тодорхойлох;
- Судалгааны аргачлал боловсруулах;
- Судалгаа явуулах;
- Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх;
- Судалгааны үр дүнгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Судалгааны үр дүнг бичлэгийн хэлбэрт оруулах гэсэн алхамууд багтаж байна.

Б.Цогбадрах өөрийн илтгэлдээ эрдэм шинжилгээний өгүүлэл бичих дарааллыг тодорхойлжээ. Түүний бичсэнээр:

- Бэлтгэл үе
- Тухайн сэдэвтэй холбоотой ном, зохиол, судалгааны материал цуглуулах үе
- Бичилтийн үе
- Хянах, нягтлах, шалгах үе гэсэн үе шаттай байна.

Улмаар Б.Цогбадрах өөрийн илтгэлдээ шинжлэх ухааны сэтгүүлд бие даан хийсэн судалгааны өгүүлэл гаргах судалгааны өгүүллийн бүтцүүдийн нэг болох IMRAD (Introduction, Method, Results, and Discussion) бүтцийн талаар дурдсан байна. IMRAD бүтэц дээр тулгуурлан өгүүллийн бүтэц ямар байхыг:

- Удиртгал (5%)
- Арга, хэрэглэгдэхүүн (10-15%)
- Үрдүн (50-60%)
- Хэлцэмж (20-30%)
- Иш татсан ном хэвлэлийн жагсаалт
- Товчлол, түлхүүр үгс
- Хавсралт гэсэн байдлаар тодорхойлдог. Энэ мэтээр олон тооны судалгааны өгүүллийг түүвэрлэн анализ хийж болно. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцийн шаардлагын талаар өмнөх бүлэгт авч үзсэн тул эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загварт дурдаагүй болно.

## **2. Алхамт загвар**

Бидний үзэж байгаагаар судалгааны өгүүлэл бичих чадвар нь судлаач бүрийн заавал эзэмшвэл зохих нэгэн чадвар юм. Аливаа чадварыг суралцах арга замаар өөртөө бий болгож болно. Иймд судалгааны өгүүлэл бичих чадварыг суулгах суралцах аргачлал буюу Алхамт загварыг энд өгүүлсүгэй.

*Үндсэн санаа:* Өгүүлэл бичих асуудлыг тогтолцооны онол буюу системийн онолын үүднээс харах шаардлагатай. Системийн ерөнхий онолыг (General systems theory) XX зууны 30-аад онд Австрийн биологич, онолч Людвиг фон Берталанфи боловсруулан гаргажээ. Түүний онолоор бол аливаа зүйлийг тус тусад нь салгаж үзэх биш харин тогтолцоогоор нь буюу бүхлээр нь харж хандах нь зүйтэй.

Энэ онолыг эрдэм шинжилгээний өгүүлэл бичих үйлд ашиглах нь зүйтэй хэмээн үзэж доорх санааг дэвшүүлж байна.

Алхам 1. Судалгааны чиглэлээ тогтоох;


Алхам 2. Тогтоосон чиглэлээрээ суурь уншлага хийж, уншиж судалсан материалуудаараа системтэй тэмдэглэл үүсгэн сан бүрдүүлэх;

Алхам 3. Цуглуулсан сан дээрээ дүгнэлт өгч өөрийн оруулах хувь нэмрийг тодруулах;

Алхам 4. Эхэлж байгаа судалгааныхаа шинэлэг санааг баталгаажуулах зорилгоор чиглэсэн уншлагуудыг хийх;

Алхам 5. Санаагаа дүрсжүүлэх;

- Алхам 6. Санаагаа математик аппаратаар томъёолох;  
 Алхам 7. Ханан илтгэл тавьж хэлэлцүүлэх;  
 Алхам 8. Нэг хуудсанд багтаан санаагаа шинжлэх ухааны үндэслэлтэй болгон бичих;  
 Алхам 9. 2 хуудас товч өгүүлэлийг эх хэл дээрээ бичих;  
 Алхам 10. Бичсэн өгүүлэлээ холбогдох сэтгүүлд хэвлүүлэх;  
 Алхам 11. Дотоодын хуралд илтгэл хэлэлцүүлэх;  
 Алхам 12. Бүрэн хэмжээний өгүүллийг 4-8-н хуудсанд багтаан бичих;  
 Алхам 13. Мэргэжлийн сэтгүүлд бүрэн хэмжээний өгүүлэл нийтлүүлэх;  
 Алхам 14. Гадаад хэл дээр богино хэмжээний өгүүлэл бичих;  
 Алхам 15. Олон улсын хуралд богино хэмжээний өгүүлэлээ илгээх, засварлах давтан илгээх;  
 Алхам 16. Ханан илтгэлийг гадаад хэл дээр тавьж хэлэлцүүлэх;  
 Алхам 17. Бүрэн хэмжээний өгүүллийг гадаад хэл дээр бичих;  
 Алхам 18. Олон улсын хуралд бүрэн хэмжээний өгүүлэл илгээх, засварлах давтан илгээх;  
 Алхам 19. Аман хэлэлцүүлгийг олон улсын хуралд хэлэлцүүлэх;  
 Алхам 20. Гадаад хэл дээрх мэргэжлийн сэтгүүлд өгүүлэлээ илгээх, засварлах давтан илгээх, хэвлүүлэх.



Зураг 1. Алхамт загвар

### 1.5. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх мэргэжлийн сэтгүүлийг сонгох асуудал

Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, судалгааны байгууллагуудаас хэд хэдэн сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргадаг. Үүнд:

№	Эрхлэн гаргадаг байгууллага	Чиглэл	Сэтгүүлийн нэр
1.	Улсын Дээд Шүүх	Хууль зүй	Монголын төр, эрх зүй
2.	Шүүхийн ерөнхий зөвлөл		Шүүх эрх мэдэл
3.	Үндсэн хуулийн цэц		Үндсэн хуулийн шүүх

			эрх мэдэл
4.	Хүний эрхийн үндэсний комисс		Хүний эрх
5.	Авлигатай тэмцэх газар		Шударга ёс
6.	Хууль зүйн үндэсний хүрээлэн		Хууль дээдлэх ёс
7.	Монголын Хуульчдын холбоо		Mongolian law review
8.	Монголын өмгөөлөгчдийн холбоо		Өмгөөлөгч
9.	МУИС-ийн Хууль зүйн сургууль		Эрх зүй
10.	Их засаг олон улсын их сургууль		Их засаг
11.	Стратегийн судалгааны хүрээлэн	Стратеги	Стратегийн судалгаа
12.	Олон улсын харилцааны хүрээлэн	Аюулгүй байдал, гадаад бодлого, олон улсын харилцаа	Олон улс судлал
13.	Боловсролын шинжлэх ухааны академи	Сурган, заах арга зүй	Боловсрол судлал
14.	ТЕГ-ын Үндэсний тагнуулын академи	Аюулгүй байдал	Тусгаар тогтнол
15.	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	Түүх-Монгол судлал	Монгол судлалын чуулган

Хууль сахиулахын их сургуулийн бүрэлдэхүүн сургууль, нэгжээс хэд хэдэн эрдэм шинжилгээний сэтгүүлийг эрхлэн гаргадаг. Үүнд:

№	Эрхлэн гаргаж буй бүрэлдэхүүн сургууль, нэгж	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргаж эхэлсэн он
1.	Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн	Хууль сахиулахуй	2014
2.	Хэвлэл, редакцийн хэлтэс, Монголын Криминологчдын холбоо	Гэмт явдалтай тэмцэх асуудал	2002
3.	Хууль сахиулахын удирдлагын академи	Хууль сахиулахуйн удирдлага	2014
4.	Цагдаагийн сургууль	Цагдаа судлал	2012
5.	Хилийн сургууль, Монголын хил судлалын үндэсний нийгэмлэг	Хил судлал	1997
6.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал	2011
7.	Онцгой байдлын сургууль	Гамшгийн эрсдэл судлал	2013

1665 онд Францын нийслэл Парис хотноо “Journal des savants” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарч байсан бол өнөөдөр дэлхий даяар хэдэн арван мянган эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлэгдэн гарч, тэдгээрт хэдэн саяар тоологдох эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдэж байна. Зөвхөн 2014 онд Томсон-Ройтерсын индекстэй 287 нийгмийн шинжлэх ухааны сэтгүүлд 22.715 өгүүлэл хэвлэгджээ.

Эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүлэл, судлаачдын тоо, хэт олширсноос шалтгаалан аливаа нэгэн эрдэм шинжилгээний сэтгүүл, хувь судлаачийн ажлын чансааг өөр нэг сэтгүүл буюу судлаачийн санал, шүүмжлэлээр (реценз) дүгнэхэд улам бүр хүндрэлтэй болж байна. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн зууны дунд үед үндэс суурь нь тавигдсан гэж үздэг сайентометрикийн ухаан сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. Сайентометрик буюу Оросоор наукометрия нь шинжлэх ухааныг математикийн аргуудаар судлах тухай ухаан юм.

Тиймээс дэлхийн нэр хүнд бүхий сэтгүүл ихэнх тохиолдолд нь математик, статистикийн аргачлалаар судалгааны эх сурвалжид боловсруулалт хийсэн эрдэм шинжилгээний өгүүлийг хүлээж авах хандлагатай болсон бөгөөд энэ шалгуураар судалгааны ажлын үр дүн бодит үнэнд нийцсэн эсэхийг дүгнэдэг байна.

Судлаач нь эрдэм шинжилгээний өгүүлээ ямар сэтгүүлд нийтлүүлэх талаар судалгаа хийх шаардлагатай. Сэтгүүлүүдийн нэр хүнд, хамрах хүрээ харилцан адилгүй байх тул сонголтыг зөв хийх хэрэгтэй. Судлаач өөрийн салбарын нэр хүнд бүхий сэтгүүлийн талаар хангалттай мэдээлэлтэй байх нь чухал. Тиймээс Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдад эрдэм шинжилгээний өгүүлээ нийтлүүлж болох олон улсад нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлүүдийн талаар мэдээлэл хүргэе.

Хууль сахиулах салбарын нэр хүнд бүхий 57 сэтгүүлийн эхний 10-т эрэмбэлэгдэж буй сэтгүүлийн жагсаалт (2015 он)

Эрэмбэ	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргадаг улс
1.	Criminology	АНУ
2.	Crime and Delinquency:	АНУ
3.	Criminal Justice and Behavior	АНУ
4.	Sexual Abuse: A Journal of Research and Treatment:	АНУ
5.	Journal of Criminal Law and Criminology	АНУ
6.	British Journal of Criminology	Их Британи
7.	Journal of Research in Crime and Delinquency	АНУ
8.	Journal of Quantitative Criminology	АНУ
9.	Punishment & Society	АНУ
10.	Journal of Interpersonal Violence	АНУ

Эх сурвалж: <http://libguides.unf.edu/c.php?g=177086&p=1163690>

Хууль сахиулах салбарын нэр хүнд бүхий 57 сэтгүүлийн эхний 10-т эрэмбэлэгдээгүй боловч эрдэм шинжилгээний өгүүллээ илгээх боломжтой сэтгүүлийн жагсаалт (2015 он)

Салбар	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргадаг улс
Цагдаа судлал	<a href="#">Police Practice &amp; Research: An International Journal</a>	АНУ
	<a href="#">Police Quarterly</a>	АНУ
	Policing: An International Journal of Police Strategies & Mangement	АНУ
	<a href="#">Policing &amp; Society</a>	АНУ
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал	<a href="#">Corrections Today</a>	АНУ
	Punishment & Society: The International Journal of Penology	АНУ
Шинжлэн магадлахуй	<a href="#">Journal of Forensic Sciences</a>	АНУ
	<a href="#">Forensic Science Guide to Crime Science Investigation</a>	АНУ

Эх сурвалж: <http://libguides.unf.edu/c.php?g=177086&p=1163690>

Дээрх эрэмбийг олон улсад нэр хүнд бүхий Elsevier өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан жил бүр гаргадаг бөгөөд олон улсын шинжтэй сэтгүүлүүдийг эрэмбэлэдэг.

Зөвхөн хууль сахиулах салбарын эхний 10-т багтсан болон энэ салбарын эрдэмтэн, судлаачид өгүүллээ илгээх боломжтой сэтгүүлийн жагсаалтыг харууллаа. Эдгээр сэтгүүлүүд нэр хүндтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тул өгүүлэл нийтлүүлэхэд хялбархан биш боловч өгүүлэлд тавигдах шаардлага зэргээс хамаарч судалгааны арга зүй эзэмшихэд олон талын ач холбогдолтой. Ерөнхийдөө сэтгүүлүүд өөрсдийн баримталдаг бодлого, зорилго зэргээс хамаарч өгүүлэл хүлээн авахдаа редакцийн хяналт хатуу тавьдаг. Нөгөө талаас, сэтгүүлүүд нь судлаачийн бүтээлийг агуулгын хувьд өмнө нь дугаарт хэвлэгдэж байсантай төстэй, дэвшүүлж буй санал нь шинэлэг биш, эсхүл дүгэлтүүд нь судалгааны арга зүйд тулгуурлаагүй байна гэж үзсэн тохиолдолд хэвлэхээс татгалзадаг. Тиймээс судлаачид мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх зорилгын хүрээнд тухайн сэтгүүлийн талаар мэдээлэл сайтай байх шаардлагатай.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН БАГШ, СУДЛААЧДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛИЙН ЧАНАР, ТҮҮНИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ**

Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачид судалгааны их сургууль болох, боловсролын салбарт инновацийг нэвтрүүлэх талаарх төрөөс баримталж буй бодлогыг дэмжин ажиллаж ирсэн. Тухайлбал, тус их сургуулийн багш, судлаачид 2011 оны 08 дугаар сараас өнөөг хүртэлх хугацаанд дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 933, үүнээс зөвхөн 2015 онд 345 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, өгүүллийн тоо жил тутам өссөн үзүүлэлттэй байна. Нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо харьцангуй өндөр боловч чанарын хувьд анхаарах шаардлагатай байна. Үүнийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн шинжлэх ухааны салбарт ишлэл авах эрх бүхий импакт, фактор бүхий сэтгүүлд тус сургуулийг төлөөлсөн эрдэм шинжилгээний өгүүлэл өнөөг хүртэл нийтлэгдээгүй байгаагаас харж болно.

Иймд тус их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын судалгаа хийх, үнэлэлт өгөх, чанарыг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор 50 эрдэм шинжилгээний өгүүллийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, өгүүллийн олон улсад мөрдөж байгаа стандарт, бүтцийн дагуу 10 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 20 дэд үзүүлэлтээр /хүснэгт №1-ийг үзнэ үү/ Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноогоор үнэлж, үр дүнг нэгтгэв.

Санамсаргүй түүвэр хийхдээ их сургуульд одоо ажиллаж буй багш, судлаачдын нийтлүүлсэн, тус их сургуулийн бэлтгэж буй мэргэжлийн чиглэл тус бүрийн эрдэм шинжилгээний өгүүллийг хамруулахыг хичээсэн болно.

Гадаадын болон дотоодын бусад их, дээд сургууль, судалгааны байгууллагаас эрхлэн гаргаж буй сэтгүүлд манай сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийг хамруулаагүй бөгөөд зөвхөн Хууль сахиулахын их сургуулиас эрхлэн гаргадаг нэр бүхий 7 онол, арга зүй, мэдээллийн сэтгүүлийг хамруулсан болно. Гэхдээ энэ нь судалгааны үр дүнд нөлөөлөхгүй гэж үзсэн.

### **Нэг. Судалгааны дүн**

1.Судалгаанд оролцогчдын 47 хүн хувь 88.6% нь Хууль сахиулахын их сургуульд багш, 6 хүн буюу 11.4% нь эрдэм шинжилгээний ажилтан байна.

2. Оролцогчдын 8162% нь эрэгтэй, 18.8% нь эмэгтэй багш, судлаач байв.

3.Судалгаанд оролцогчдын 13 хүн буюу 24.5% нь доктор, 40 хүн буюу 75.5% нь магистрын зэрэгтэй байна.

4.Их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийг мэдлэгийн тодорхой салбараар төрөлжүүлэн нь авч үзвэл 31 буюу 62% нь гэмт явдал судлал, 4 буюу 8% нь шинжлэн магадлахуй, 4 буюу 8% нь хил судлал, 4 буюу 8% нь шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, 4 буюу 8% нь гамшгийн эрсдэл судлал, 3 буюу 6% нь удирдахуйн ухааны өгүүлэл байв.

5.Их сургуулийн багш, судлаачдын эрдэм шинжилгээний өгүүллийг нийтлүүлсэн мэргэжлийн сэтгүүлийн төрлөөр нь авч үзвэл: 19 буюу 38% нь “Хууль сахиулахуй”, 14 буюу 28% нь “Гэмт явдалтай тэмцэх асуудал”, 1 буюу 2% нь “Гамшгийн эрсдэл судлал”, 3 буюу 6% нь “Хил судлал”, 3 буюу 6% нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал”, 3 буюу 6% нь “Хууль сахиулахуйн удирдлага”, 7 буюу 14% нь “Цагдаа судлал” онол, арга зүйн сэтгүүлд тус тус нийтлэгдсэн байв.

6.Нийт эрдэм шинжилгээний өгүүллийн 47 буюу 94%-ийг дангаараа, 3 буюу 6%-ийг хамтран бичиж, нийтлүүлсэн байна. Харин олон улсад эрдэм шинжилгээний өгүүллийг судлаачид дангаараа бичиж нийтлүүлэхээс илүүтэйгээр хамтран бичих хандлагатай байна.



7.Эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн багш, судлаачдыг бүрэлдэхүүн сургуулиар нь авч үзвэл, 22 буюу 41.5%-ийг Цагдаагийн сургууль, 5 буюу 9.4%-ийг Хууль сахиулахын удирдлагын академи, 4 буюу 7.5%-ийг Хилийн сургууль, 4 буюу 7.5%-ийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, 2 буюу 3.7%-ийг Онцгой байдлын сургууль, 6 буюу 11.3%-ийг Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, 1 буюу 1.8%-ийг Ахлагчийн сургууль, 7 буюу 13.2%-ийг Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, 2 буюу 3.7%-ийг бусад нэгж тус тус эзэлж байна.

### **Хоёр. Агуулгын дүн**

Санамсаргүй түүврээр сонгосон 50 эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсад мөрдөж байгаа стандарт, бүтцийн дагуу 10 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 20 дэд үзүүлэлтээр үнэлж, өгүүллийн чанарын түвшинг тодорхойлоход олон улсын стандартад бүрэн нийцсэн, эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцийн шаардлага хангасан өгүүлэл байхгүй байгаагийн зэрэгцээ дор дурдсан нийтлэг дутагдал байна.Үүнд:

#### **1. Өгүүллийн нэр (Title):**

Багш, судлаачид сэдвийн агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй, сэдвийн агуулгад нийцэхгүй нэр өгүүлэлдээ өгчээ. Тухайлбал,

- “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>505</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн нэр нь сэдвийн агуулгыг бүрэн илэрхийлж чадаагүй байна. Аюулгүй байдал нь өргөн хүрээтэй ойлголт боловч, хэдхэн тооны жишээг онцгойлон дурдсан.
- “Хүчирхийлэл гэмт явдал болох нь”<sup>506</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн нэр агуулгатай нийцээгүй, оновчгүй томъёолсон.

#### **2. Хураангуй (Abstract):**

Багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллээс үзэхэд, эрдэм шинжилгээний өгүүллийн олон улсад мөрдөгдөж байгаа бүтцийн шаардлагыг баримтлаагүй хураангуй байхгүй 18 өгүүлэл байна. Тухайлбал, “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалтад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”<sup>507</sup>, “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>508</sup>, “Ялтан сэтгэл зүйн хямралд орох шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэн даван туулах арга зам”<sup>509</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл хураангуй, түлхүүр үг байхгүй.

#### **3. Түлхүүр үг (Keywords):**

Судалгаанд хамрагдсан эрдэм шинжилгээний өгүүллийн 62% нь түлхүүр үг хэрэглэсэн боловч өгүүллийн үндсэн утга санааг төлөөлөхүйц цөөн үгийг оновчтой сонгож хэрэглээгүй дутагдал байна.

#### **4. Удиртгал (Intraduction):**

Багш, судлаачид судалгааны объект, судалгааны зорилго, зорилтоо оновчтой тодорхойлоогүй, судалгааны сэдвийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болохыг илэрхийлээгүй зэрэг нийтлэг дутагдал байна. Тухайлбал,

- “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>510</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн удиртгал хэсэгт энэхүү судалгаагаар ямар асуудлыг хөндөн авч үзэх талаар бага зэрэг дурдсан боловч, судалгааны зорилго, түүнд хүрэх зорилтоо тусгаагүй, энэхүү судалгааг өмнө нь гадаадын болон дотоодын эрдэмтэн судлаачид хэрхэн судалсан,

<sup>505</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>506</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>507</sup> “Хууль сахиулахын удирдлага” сэтгүүл. 2015. №1 (02)

<sup>508</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>509</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№1 (13)

<sup>510</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

тэрхүү судалгааны үр дүнгээс судлаачийн энэ удаагийн судалгаа ямар онцлогтой болохыг дурдаагүй байна.

- “Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн, зүйлчлэлийн зарим асуудал”<sup>511</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн удиртгал хэсэгт судалгааны зорилго, тулгамдсан асуудлыг тодорхой дурдаагүй байгаа нь үндсэн хэсэгт дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.
- “Техникийн ашиглалтын тухай ойлголт, түүний үзүүлэлтүүд”<sup>512</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн удиртгал хэсэгт судалгааны сэдвийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болохыг илэрхийлээгүй. Өөрөөр хэлбэл, техникийн ашиглалт, түүний үзүүлэлтүүдийг тодорхойлоход ямар асуудал тулгамдаж, шийдэл хүлээгдэж байгаа талаар дурдаагүй байна.
- “Цагдаагийн алба хаагч цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах үндсэн хүч мөн”<sup>513</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт зорилго, зорилтоо тодорхойлоогүй, тухайн асуудлын мөн чанарыг тайлбарласан шинжтэй мэдээлэл их байна. Судалгааны ажил тодорхой арга зүй, мэдээллийн баазад тулгуурлаагүй боловч тодорхой дүгнэлтүүд хийсэн нь судалгааны ажлын үнэн бодит байдлыг алдагдуулжээ.
- “Цахилгаан чийдэнгийн галын аюулгүйн шаардлага”<sup>514</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт судалгааны сэдвийн үндэслэл, шаардлага, зорилго, зорилтоо тодорхойлоогүй.
- “Хүчирхийлэл гэмт явдал болох нь”<sup>515</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт зорилго, зорилтоо тодорхойлоогүй, тухайн сэдвийг судлах судалгааны арга зүй, хүчирхийлэл нь гэмт явдал болох эсэх асуудлыг хэрхэн судлах талаар дурдаагүй байна.
- “Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг хуульчилж ирсэн түүхэн уламжлал”<sup>516</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт судалгааны ач холбогдлыг тайлбарласан боловч энэхүү судалгааны зорилго, зорилт, судалгааны арга зүй, мэдээллийн эх сурвалжийг ямар бүтээлээс авсан талаарх мэдээлэл тодорхойлоогүй байна. Түүнчлэн, энэхүү сэдвийн өмнө судлагдсан байдлын талаар дурдаагүй нь илтгэлийн шинэлэг талыг танин мэдэхэд хүндрэл учруулжээ.
- “Нуугдмал гэмт хэрэг: ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал”<sup>517</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт эрдэм шинжилгээний өгүүллийн зорилгыг тодорхойлоогүй байгаа нь дүгнэлтүүд үндэслэлтэй эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

## 5. Судлагдсан байдал (Literature review)

- Судалгаанд хамрагдсан эрдэм шинжилгээний өгүүлэлд судлагдсан байдал буюу судалгааны объектыг бусад судлаачид судалсан байдал, тэдний арга, аргачлалын талаар огт дурдаагүй байна. Тухайлбал, “Цахилгаан чийдэнгийн галын аюулгүйн шаардлага”<sup>518</sup> сэдэвт өгүүлэлд өмнө нь хийгдсэн судалгааны ажлаас ялгагдах онцлог, давуу болон сул талыг дурдаагүй байна.

## 6. Үндсэн хэсэг

Багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн 64% нь оновчтой таамаглал дэвшүүлээгүй, дэвшүүлсэн таамаглалыг шалгах арга, аргачлалын талаар дурдаагүй, дэвшүүлсэн таамаглал хэрхэн батлагдсан талаар судалгааны үр дүнг илэрхийлээгүй, судалгаагаар батлагдаагүй таамаглалд үндэслэн санал, зөвлөмж

<sup>511</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>512</sup> Хил судлал сэтгүүл. 2013.№01-02 (33, 34)

<sup>513</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>514</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

<sup>515</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>516</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>517</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№1 (01)

<sup>518</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

боловсруулжээ. Тухайлбал,

- “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>519</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн үндсэн хэсэгт судалгааны зорилгодоо хүрэхийн тулд дэвшүүлсэн таамаглал, асуулт байхгүй байна. Өгүүллийн 9 дүгээр талд “Хэвлэл мэдээлэл нь санаатайгаар эсвэл хайхрамжгүйгээс болж ялгаварлан гадуурхах, хүч хэрэглэх үзлийг хөөрөгдвөл ноцтой аюул үүсэж болно” гэсэн судлаачийн таамаглалын шинжтэй өгүүлбэр байх боловч түүнийгээ таамаглал болгон дэвшүүлээгүй байна. Зарим хоёрдогч эх сурвалжуудыг судалгаанд ашигласан боловч түүнийг хэрхэн ямар шалгуураар сонгон авсан, судалгааны зорилгод хамаарах мэдээлэл мөн эсэх, сонгож авсан мэдээлэлд судалгааны ямар арга ашиглаж дүн шинжилгээ хийсэн нь тодорхойгүй байна. Иймээс судалгааны тодорхой үр дүн гараагүй, дэвшүүлсэн таамаглалаа ямар нэгэн байдлаар шалгаагүй атал цагдаагийн албан хаагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нарт хандсан зөвлөмж гаргасан нь хийсвэр шинжтэй. Тиймээс энэхүү судалгааны ажлын эцэст дэвшүүлсэн 2 төрлийн санал нь судалгаагаар батлагдаагүй таамаглалын шинжтэй санал байх өндөр магадлалтай.
- “Ялтан сэтгэл зүйн хямралд орох шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэн даван туулах арга зам”<sup>520</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд ялтны сэтгэл зүйн хямрал, гутралын шалтгааны талаар хэд хэдэн таамаглал дэвшүүлсэн боловч судалгааны аргын тусламжтайгаар таамаглалаа шалгаагүй тул боловсруулсан санал-зөвлөмж бодитой эсэх нь эргэлзээтэй байна.
- “Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн, зүйлчлэлийн зарим асуудал”<sup>521</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн үндсэн хэсэгт тухайн гэмт хэргийн ойлголтыг тодорхойлсон боловч тодорхой судалгааны арга зүйд тулгуурлан судалгаа хийгээгүй байна. Тухайлбал, статистик мэдээнд болон зүйлчлэлийн маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгоор тодорхой тохиолдлуудад шинжилгээ хийгээгүй, онолын маргаантай нэр томъёо, ойлголтуудыг харьцуулан судлах замаар тодорхой дүгнэлт боловсруулаагүй.
- “Хүчирхийлэл гэмт явдал болох нь”<sup>522</sup> сэдэвт өгүүллийн үндсэн хэсэгт судлаачийн санаа, судалгааны материалд тулгуурлаагүй хуулбарласан шинжтэй байна. Тухайлбал, доктор Б.Батзоригийн “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүлийн 2008 оны №1 дугаарт хэвлэгдсэн “Дэлхийн криминологийн хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний өгүүлэл, доктор, профессор Н.Жанцан.“Криминологи”. УБ., 2005 сурах бичгийн гэмт явдал, түүний шинж гэсэн бүлгээс “Гэмт явдал” гэсэн нэр томъёог “Хүчирхийлэл” гэсэн үгээр сольж хуулбарласан.
- “Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг хуульчилж ирсэн түүхэн уламжлал”<sup>523</sup> сэдэвт өгүүллийн үндсэн хэсэгт Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийг судалж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг ялгаатай байдлаар хуульчилж ирсэн байдлыг нээн илрүүлсэн боловч ямар учир шалтгааны улмаас ялгаатай байсан талаарх таамаглал дэвшүүлж судлаачийн зүгээс тайлбарлах оролдлого хийгээгүй байна.
- “Цахилгаан чийдэнгийн галын аюулгүйн шаардлага”<sup>524</sup> сэдэвт өгүүллийн үндсэн хэсэгт сэдэвтэй холбоотой ойлголтуудыг тодорхойлсон боловч, судалгааны арга зүй, ямар хүрээнд судалгааг явуулсан, бусдын хийсэн судалгааг ашигласан боловч, ишлэл аваагүй байна.

<sup>519</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>520</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№1 (13)

<sup>521</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>522</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>523</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>524</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

- “ХСИС-ийн дидактикийн шинэчлэл: үнэлгээний даалгавар боловсруулах арга зүй”<sup>525</sup> сэдэвт өгүүллийн үндсэн хэсэгт логикийн уялдаа холбоогүй зарим зүйл байна. Тодорхой хүрээнд судалгаа явуулж дүн шинжилгээ хийсэн нь сайшаалтай боловч онолын болон тодорхой загварчлалын хэсгүүд нь судалгааны хэсэгтэй холилдсон, дүгнэлтэд дурдсан нь логикийн алдаа үүсгэж байна. Түүнчлэн, дүгнэлт хэсэгт зөвхөн судалгааны ажилтай холбоотой дүгнэлтүүдийг хийгээгүй байна.
- “Монгол бичгийн онцлог, шинж тэмдгийг шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэх нь”<sup>526</sup> сэдэвт өгүүлэл нь бүтцийн шаардлага хангаагүй байна. Судалгааны үр дүн, практик ач холбогдол нь өндөр боловч судалгаа явуулсан арга зүйгээ тодорхойлж тусгаагүй байгаа нь судалгааны ажлын үнэн бодит байдлыг эргэлзээ төрүүлж байна.

## 7. Хэлэлцүүлэг:

- Судалгаанд хамрагдсан эрдэм шинжилгээний өгүүллүүдээс үзэхэд хэлэлцүүлэг (Discussion) хэсэг байхгүй байна. Тухайлбал, судлаач өөрийн судалгааны ач холбогдол, түүний үр дүнг практикт хэрхэн хэрэглэх талаар дурдаагүй, бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, зөвлөмж, санал дэвшүүлээгүй, судалгааны цаашдын чиглэл, алхам юу байх талаар тусгаагүй.

## 8. Дүгнэлт, санал (Conclusion, recommendation)

Судалгаанд хамрагдсан эрдэм шинжилгээний өгүүллээс үзэхэд, дэвшүүлсэн судалгааны зориг, таамаглалтай холбож, судалгааны үр дүнд үндэслэн оновчтой дүгнэлт хийгээгүй, хэт ерөнхий, судалгааны сэдэвтэй хамааралгүй дүгнэлт хийсэн, судалгаанд үндэслээгүй, практикт хэрэгжих, үр дүн өгөх боломжгүй санал дэвшүүлсэн зэрэг нийтлэг дутагдал байна. Тухайлбал,

- “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалтад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”<sup>527</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт явуулахад тулгамдаж буй асуудлын талаар таамаглал дэвшүүлж, улмаар дэвшүүлсэн таамаглалаа судалгааны аргын тусламжтайгаар шалгаагүй, судалгаанд үндэслэсэн судалгааны зорилгыг хангах дүгнэлт, санал-зөвлөмж боловсруулаагүй.
- “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>528</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн дүгнэлт нь сэдвийн агуулга, зорилготой нийцээгүй, явцуу хүрээнд хийсэн, тухайлбал, зөвхөн “нийслэл”-ийн асуудлыг тодорхойлсон дүгнэлт байна.
- “Цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн, зүйлчлэлийн зарим асуудал”<sup>529</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд дүгнэлт санал байхгүй.
- “Гамшгийн үед хотын тогтвортой байдлыг дээшлүүлэх нь”<sup>530</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл нь дүгнэлт, хураангуй, түлхүүр, үг, ашигласан материалын жагсаалтгүй байна.
- “Цагдаагийн албан хаагч цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах үндсэн хүч мөн”<sup>531</sup> сэдэвт өгүүллийн дүгнэлтүүд нь таамаглалын шинжтэй байна.
- “Хүчирхийлэл гэмт явдал болох нь”<sup>532</sup> сэдэвт өгүүллийн дүгнэлт хэсэгт хүчирхийлэл гэдгийг тодорхойлсон боловч ямар судалгааг үндэслэж тодорхойлолт хийсэн нь тодорхойгүй, асуудлыг зөвхөн хөндөөд орхисон байна.

<sup>525</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№1 (01)

<sup>526</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

<sup>527</sup> “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл. 2015. №1 (02)

<sup>528</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>529</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>530</sup> Гамшгийн эрсдэл судлал сэтгүүл. 2013. №1 (01)

<sup>531</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>532</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

- “Техникийн ашиглалтын тухай ойлголт, түүний үзүүлэлтүүд”<sup>533</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл нь судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлсэн дүгнэлт, санал байхгүй.
- “Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын насыг хуульчилж ирсэн түүхэн уламжлал”<sup>534</sup> сэдэвт өгүүллийн дүгнэлт, санал шинэлэг биш, өмнөх судалгааны ажлуудыг өрөгжүүлж чадаагүй байна.
- “Цахилгаан чийдэнгийн галын аюулгүйн шаардлага”<sup>535</sup> сэдэвт өгүүллийн дүгнэлтүүд нь өөрийн судалгааны ажлын үр дүнд хийгдээгүй байна.

### **9. Ашигласан материалын бичиглэл (Reference):**

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихдээ ашигласан материалыг дурдаагүй судалгааны ажилд огт хамааралгүй эх сурвалжийг ихээр бичсэн нийтлэг дутагдал байна. Тухайлбал, “Хилийн аюулгүй байдлыг хангах талаар ОХУ-ын төрөөс баримталж буй улс төр-дипломат бодлого”<sup>536</sup>, “Хэвлэл мэдээлэл ба аюулгүй байдал”<sup>537</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд ашигласан материалын жагсаалт, түлхүүр үгс байхгүй, ишлэлийг стандартын дагуу аваагүй.

### **10. Бичлэгийн стандарт, зааврыг баримталсан байдал:**

Их сургуулийн захирлын ... дугаар тушаалаар баталсан “Хууль сахиулахын их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандарт”-ийг баримтлан бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл байхгүй байна.

Монгол хэлний зөв бичих дүрмийн алдаа түгээмэл байна. Тухайлбал, “Ялтан сэтгэл зүйн хямралд орох шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэн, даван туулах арга зам”<sup>538</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийн нэр болон судлаачдын танилцуулгад л Монгол хэлний зөв бичих дүрмийн 5 алдаа гаргажээ.

### **11. Ишлэл авсан байдал:**

Ишлэлийг олон улсад мөрдөгдөж байгаа стандартад (APA, MLA) нийцүүлэн аваагүй байдал түгээмэл байх бөгөөд огт ишлэлгүй эрдэм шинжилгээний өгүүлэл цөөнгүй байгаа нь анхаарал татсан. Тухайлбал, “Монгол бичгийн онцлог, шинж тэмдгийг шүүхийн шинжилгээний практикт нэвтэрүүлэх нь”<sup>539</sup> сэдэвт өгүүлэлд ишлэл зүүлт огт аваагүй байна.

Хууль сахиулахын их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд, дээр дурдсан дутагдал байх боловч олон улсын стандарт, өгүүллийн бүтцэд нийцсэн зүйл цөөнгүй байна. Тухайлбал,

- “Нуугдмал гэмт хэрэг: ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал”<sup>540</sup> сэдэвт өгүүллийн үндсэн хэсэгт тухайн сэдэвтэй холбоотой ойлголтууд, нэр томъёог оновчтой тодорхойлж, нуугдмал гэмт хэргийг тооцох аргачлалыг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээг ашиглан тооцоолох арга зүйг дурдсан байна. Дүгнэлт, санал оновчтой болсон байна. Энэхүү илтгэл нь эрдэм шинжилгээний ажлын тодорхойлон тайлбарласан /descriptive study/ хэлбэрт хамаарах бөгөөд энэ төрлийн илтгэлийн зорилго нь чанарын судалгааны /[qualitative](#) research/ сэдэв, эсхүл тодорхой таамаглалыг бий болгоход чиглэгдсэн байдаг.

<sup>533</sup> Хил судлал сэтгүүл. 2013.№01-02 (33, 34)

<sup>534</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№2 (48)

<sup>535</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

<sup>536</sup> Хил судлал сэтгүүл. 2013.№01-02 (33, 34)

<sup>537</sup> “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014.№1 (47)

<sup>538</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№1 (13)

<sup>539</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№3, 4 (07, 08)

<sup>540</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№1 (01)

- “Насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн харьцуулсан судлалын асуудал”<sup>541</sup> сэдэвт өгүүллийн удиртгал хэсэгт судалгааны зорилго, судлах зүйлийг тодорхойлж, үндсэн хэсэгт судалгааны ажлын зорилгод нийцүүлэн харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт, санал дэвшүүлсэн байна.
- “ХСИС-ийн дидактикийн шинэчлэл: үнэлгээний даалгавар боловсруулах арга зүй”<sup>542</sup> сэдэвт өгүүлэл нь эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах бүтцийн шаардлагыг хангаж байна. Сэдвийн томъёолол оновчтой, ямар нэгэн асуудлыг хэрхэн судлах талаар шууд ойлгогдож байгаа нь илтгэлийн ач холбогдлыг өндөрсгөж байна.

2016 оны 06 дугаар сарын байдлаар Хууль сахиулахын их сургуульд 160 орчим багш, 26 эрдэм шинжилгээний ажилтан, сургалт, эрдэм шинжилгээний ажил эрхлэх чиг үүрэг бүхий удирдах албан тушаалтан 15 хүн тус тус ажиллаж байна. Энэ нь нийт бие бүрэлдэхүүний 30 орчим хувийг эзэлж байна.

Тус их сургууль цөөнгүй багш, эрдэм шинжилгээний ажилтантай боловч зөвхөн 76 хүн буюу нийт багш, судлаачдын зөвхөн 38% нь эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлжээ.

2015 онд Их сургуулийн багш, судлаачид нэр бүхий 7 сэтгүүлд 345 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна. Энэ хугацаанд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоог нийт багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх чиг үүрэг бүхий албан хаагчдын тоонд харьцуулбал нэг хүнд 1.7 өгүүлэл ногдож байна. Энэ бол маш бага үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтээрээ манай сургууль дотоодын 5 их, дээд сургуулийн тооны гадна үлдэж байна.

### ДҮГНЭЛТ

1. Багш, судлаачдын цөөн хувь нь эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлсэн нь багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх чиг үүрэг бүхий нийт албан хаагчдын тоонд харьцуулбал маш бага үзүүлэлттэй байна.
2. Багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл олон улсын болон дотоодын стандарт, бүтцийн болон агуулгын шаардлага хангахгүй байна.
3. Багш, судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл нь тодорхойлон тайлбарласан шинжтэй байх бөгөөд бусад хэлбэрийн өгүүллийн төрлийг сонгож бичихгүй байгаа нь судалгааны ажлын арга зүй, мэдлэг, чадвар сул, судалганы ажлыг олон арга, хэлбэрээр хийх идэвхи санаачлагагүй байгааг харуулж байна.
4. Багш, судлаачдад эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, олон улсын болон дотоодын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ илгээх, хэвлүүлэх арга зүй эзэмшүүлэх ажил хангалтгүй байна.
5. Багш, судлаачдын 85 орчим хувь нь Цагдаагийн Академи, Дотоод хэргийн их сургууль, Хууль сахиулахын их сургуульд баклавар, магистрын зэрэг эзэмшсэн боловч судалгааны арга зүй дутмаг байгаа нь энэ төрлийн хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөг шинэчлэх цаг болсныг илтгэж байна.
6. Их сургуулийн багш, судлаачдын нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн чанарын судалгааг тогтмол хийх, үнэлэлт өгөх, чанарыг дээшлүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
7. Багш, судлаачид эрдэм шинжилгээний өгүүлэл дангаараа бичиж нийтлүүлэхээс илүүтэйгээр хамтран бичиж нийтлүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Ингэснээр эрдэм шинжилгээний өгүүллийн чанар дээшилдэг болох нь олон улсын туршлагаар батлагдсан.

<sup>541</sup> Хууль сахиулахуй 2015 №3, 4 (07, 08)

<sup>542</sup> Хууль сахиулахуй сэтгүүл. 2014.№1 (01)

## САНАЛ

1. Багш, судлаачид судалгааны арга зүйн түвшнээ байнга дээшлүүлж, судалгаанд суурилсан олон улсын шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх, тооноос чанарт анхаарах;
2. Их сургуулийн магистр, докторын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан судалгааны арга зүй хичээлийн агуулга, хэлбэрийг шинэчлэх, бакалаврын сургалтад судалгааны арга зүйн үндэс, гэмт хэргийн статистикийн үндэс хичээлийг заах;
3. Судалгааны арга зүйн үндэс, судалгааны арга зүй хичээлийн үндсэн сурах бичиг бичих, мэргэшсэн судлаач багш бэлтгэх ажил зохион байгуулах;
4. Багш, судлаач бүрийг судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэн эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэх шаардлага тавьж, хэрэгжүүлэх;
5. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигддаг олон улсын стандарт, бүтцийн шаардлага, судлаачийн ёс зүйг мөрдөж ажиллах;
6. Багш, судлаачдад эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, илгээх, нийтлүүлэх талаар сургалт зохион байгуулах;
7. Их сургуулиас эрхлэн гаргаж буй мэргэжлийн сэтгүүлийн нийтлэлийн бодлого, нийтлэлийн чанарт анхаарах, эрдэм шинжилгээний өгүүлэлд тавих шаардлагыг олон улс, дотоодын түвшинд нийцүүлэх;
8. Их сургуулиас эрхлэн гаргаж буй мэргэжлийн сэтгүүлийн редакцийн зөвлөл энэ тайланд заасан өгүүллийн бүтцийн шаардлагыг хангасан өгүүллийг хүлээн авч нийтлэх бодлого баримтлах, их сургуулиас эрхлэн гаргаж буй мэргэжлийн сэтгүүлүүдийг эрэмбэлэх;
9. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн шинжлэх ухааны салбарт ишлэл авах эрх бүхий импакт, фактор бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэхэд багш, судлаачдад эдийн засгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, судалгааны ажил эрхлэх бодит нөхцлөөр хангах;
10. Багшийн эрдэм шинжилгээний багц цаг тооцох журмыг шинэчилж, зөвхөн эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах олон улсын болон дотоодын стандарт, бүтцийн шаардлага хангасан бүтээлд багц тооцох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх;
11. Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн төрөлжсөн судалгааны төв, бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн тэнхимүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдаа холбоог хангах;
12. Багш, судлаач сонгон шалгаруулж авахдаа (сайн хуульчдаас гадна, статистикч, социологич мэргэжилтнүүдээр судлаачдын хүрээг өргөжүүлэх) судалгааны арга зүй эзэмшсэн байдал, бүтээлийн чанарыг харгалзан үзэх тогтолцоонд шилжих;
13. Эрдэм шинжилгээний өгүүллийн нэгдсэн сан бий болгох;
14. Жил бүр шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг шалгаруулж, грант олгох.

## НОМ ЗҮЙ

### Илтгэл, өгүүлэл, тайлан

1. Дээд боловсрол судлалын Монголын нийгэмлэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын их, дээд сургуулиудын консорциум, Монгол Улсын Боловсролын их сургууль. “Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулахад тулгамдаж буй зарим асуудал” симпозиумын илтгэлийн эмхтгэл. УБ., 2016
2. Rich R. empirical political analysis; research methods in political science 4th ed., N.Y. Longman. 1995
3. Ж.Давааням. "Монгол Улсын их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны өнөөгийн байдал" судалгааны тайлан. 2016
4. Ц.Мөнхбат (2010), “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих чадвар” илтгэл,
5. П.Нямдаваа (2012), “Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичих хэрхэн вэ?” илтгэл
6. Б.Цогбадрах (2014), “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүй” илтгэл

### Эрдэм шинжилгээний сэтгүүл

7. Монгол Улсын боловсролын их сургууль. Эрдэм шинжилгээний бичиг. Лавай. №14
8. Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2014. №1 (01),
9. Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2014. №3, 4 (03, 04)
10. Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2015. №1 (05)
11. Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2015. №3, 4 (07, 08)
12. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2012. №3, 4 (41, 42)
13. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2013. №1 (43)
14. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2013. №2 (44)
15. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2013. №3 (45)
16. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2013. №4 (46)
17. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014. №1 (47)
18. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014. №2 (48)
19. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2014. №3 (49)
20. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2015. №2 (52)
21. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2015. №3 (53)
22. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2015. №4 (54)



23. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2016. №1 (55)
24. Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2016. №2 (56)
25. Хууль сахиулахын их сургууль. “Цагдаа судлал” сэтгүүл. 2012. №2
26. Хууль сахиулахын их сургууль. “Цагдаа судлал” сэтгүүл. 2012. №4, 2013.№1
27. Хууль сахиулахын их сургууль. “Цагдаа судлал” сэтгүүл. 2012. №4, 2013.№2
28. Хууль сахиулахын их сургууль. “Цагдаа судлал” сэтгүүл. 2013.№3 (08)
29. Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академи. “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл. 2014. № 1, 2 (01)
30. Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академи. “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл. 2015. №1 (02)
31. Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургууль, Монголын хил судлалын үндэсний нийгэмлэг. “Хил судлал” сэтгүүл. 2013.№01, 02 (33, 34)
32. Хууль сахиулахын их сургууль. “Гамшгийн эрсдэл судлал”. 2013. №1 (01)
33. Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүл. 2015. №1 (13)

**Цахим эх сурвалж:**

34. <https://www.timeshighereducation.com/world-university-rankings>